

ХАВСРАЛТ-1

**Бүс нутгийн ДНБ-ийг
тооцох арга зүйд өгөх
ЗӨВЛӨМЖ**

**Улаанбаатар
2016 он**

Агуулга

1. ҮСХ-ноос мөрдөж буй ДНБ-г тооцох арга зүй

1.1 ДНБ болон ҮНО тооцох аргачлал

1.2 Бүс нутгийн ДНБ-ийг тооцох аргачлалын төсөл

1. ҮСХ-ноос мөрдөж буй ДНБ-г тооцох арга зүй.

ҮСХ-нд бүс нутгийн ДНБ-ийг тооцох арга зүйн дараах баримт бичиг байна.

1.1 “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлого тооцох аргачлал” /ҮСХ-ны даргын 2013 оны 1/134 тоот тушаалын I хавсралтаар батлагдсан <http://web.nso.mn/AZMS/web/detail/1/>

1.2 “Бүс нутгийн ДНБ-ийг тооцох аргачлалын төсөл”.

1.1 “ДНБ болон ҮНО тооцох аргачлал”

2013 онд батлагдсан “ДНБ болон ҮНО тооцох” аргачлалын тавдугаар бүлэгт аймаг, нийслэлийн ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар тооцох арга зүй тусгагдсан байна.

Уг аргачлалд аймгийн нэмэгдэл өртгийг тооцохдоо аймгийн харьяат үйлдвэрлэгч нэгжийн үйл ажиллагааг хэмжих бөгөөд “үйлдвэрлэгч нэгжээс мэдээллийг цуглуулж, улсын түвшинд нэгтгэх” (bottom-up method) арга болон “улсын түвшинд тооцооллыг хийж, аймаг, бүсэд нь хуваарилах” (top down method) аргыг мэдээллийн эх үүсвэрийн боломжит байдалд үндэслэн ашиглан гэж тусгасан байна.

“Үйлдвэрлэгч нэгжээс мэдээллийг цуглуулж, улсын түвшинд нэгтгэх” (нэгтгэх арга) аргын хувьд тухайн аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын мэдээлэл статистик нэгжийн түвшинд нэгтгэж, түүнд үндэслэн аймаг, улсын нэгтгэлийг шууд хийх боломжтой. Харин “улсын түвшинд тооцооллыг хийж, аймаг, бүсэд хуваарилах” (задлах арга) арга нь ААНБ-ын үйл ажиллагааг аймгийн түвшинд статистик нэгжийн түвшинд тооцож, тайлан тэнцэл гаргах боломжгүй тохиолдолд уг аргыг ашиглана. Уг аргын хувьд улсын түвшинд хийгдсэн тооцоог холбогдох үзүүлэлтийг ашиглан аймгуудад хуваарилж, аймгийн нэмэгдэл өртгийг гаргана.

Аргачлалд аймгаар нэмэгдэл өртгийг тооцохдоо дараах арга зүйг баримтална гэж ерөнхий байдлаар тусгаж өгсөн байна.

1. “Үйлдвэрлэгч нэгжээс мэдээллийг цуглуулж, улсын түвшинд нэгтгэх” аргаар дараах салбарыг хамруулна зааж өгсөн байна. Үүнд:
 - Газар тариалан, мал аж ахуй (А);
 - Уул уурхай, олборлолт (В);
 - Боловсруулах үйлдвэрлэл (С);
 - Цахилгаан, хий, уур, агааржуулалт (D);

- Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа (E);
 - Барилга (F);
 - Бөөний болон жижиглэн худалдаа (G);
 - Тээвэр, агуулахын үйл ажиллагаа (H);
 - Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ (I); Мэдээлэл, холбоо (J);
 - Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа (банк, даатгалаас бусад) (K);
 - Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа (L);
 - Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа (M);
 - Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа (N);
 - Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал (O);
 - Боловсрол (P);
 - Эрүүл мэнд (Q);
 - Урлаг, үзвэр, тоглоом, наадам (R);
 - Үйлчилгээний бусад үйл ажиллагаа (S).
2. “Улсын түвшинд тооцооллыг хийж, аймаг, бүсэд хуваарилах” аргыг
 - Ан агнуур, загас барилт, ойн аж ахуй, мод бэлтгэл (A);
 - Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа (K).
 3. Албан бус секторын тооцоог улсын дүнгээр тооцож, аймгуудад хуваарилна.

1.2 Бүс нутгийн ДНБ-ийг тооцох аргачлалын төсөл

ҮСХ нь ЭЗХЯ, НҮБХХ, “МУ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд зөвлөхүүдийн гаргасан “Аймаг, нийслэлийн ДНБ-ийг нутаг дэвсгэрийн зарчмыг харгалзан үзэж хуваарилах арга зүйн санал”, “ДНБ-ийг сумын түвшинд тооцох арга зүйн санал”-ийг харгалзан, ЕВРОСТАТ-аас гаргасан “Бүс нутгийн тооцооны арга зүйн гарын авлага”¹ аргачлалд үндэслэн “Бүс нутгийн ДНБ-ийг тооцох аргачлалын төсөл”-ийг боловсруулсан байна.

Уг аргачлалын төсөл нь “ДНБ болон ҮНО тооцох аргачлал”-ын “Аймаг, нийслэлийн ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар тооцох арга зүй” (бүлэг 5)-тэй харьцуулахад нэлээд дэлгэрэнгүй болсон байна. Агуулгын хувьд ДНБ-ийг бүсчлэх арга зүй, бүсийн ДНБ-ийг тооцох (оны үнээр) арга зүй, бүс нутгийн нийт нэмэгдэл өртгийг зэрэгцүүлэх үнээр тооцох арга зүйг хамарсан байна.

¹ Eurostat “Manual on regional accounts methods”, 2013

“ДНБ болон ҮНО тооцох аргачлал”-д хэдийгээр “аймгийн нэмэгдэл өртөг нь аймгийн харьяат үйлдвэрлэгч нэгжийн эдийн засгийн үйл ажиллагааг хэмжинэ” гэж тодорхойлсон ч эдийн засгийн үйл ажиллагааны ихэнхи салбар (ан агнуур, загас барилт, ойн аж ахуй, мод бэлтгэл; санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа –наас бусад)-ыг “нэгтгэх арга” буюу “Үйлдвэрлэгч нэгжээс мэдээллийг цуглуулж, улсын түвшинд нэгтгэх” аргаар тооцно гэж тусгасан байна. Харин “Бүс нутгийн ДНБ-ийг тооцох аргачлалын төсөл”-д бүс нутгийн харьяат нэгжид суурилна гэж тодорхойлоод, хэд хэдэн бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг ААН-ийн мэдээллийг салбарын онцлогийг нь харгалзан хэрхэн бүс нутагт хуваарилах талаар дэлгэрэнгүй тусгасан байна. Мөн бүс нутгийн тооцооны үнэн бодит байдлыг үнэлэх аргуудыг тусгасан нь ОУ-ын нийтлэг зарчмыг баримтлахын зэрэгцээ энэ нь шинэлэг асуудал тусгаж өгсөн байна. Өөрөөр хэлбэл, үнэлгээний аргыг тусгасан нь ашиглаж буй мэдээллийн эх үүсвэрээсээ шалтгаалан одоо мөрдөж байгаа арга зүйгээ (А, В, С арга) үнэлээд, ямар тохиолдолд үнэлгээний дараагийн шатанд хүрэх боломжтойг тусгаж өгсөнөөрөө ач холбогдолтой гэж үзэж байна. Жишээ нь, хэд хэдэн аймагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн мэдээллийг холбогдох аймгуудад нь хуваарилахдаа ажиллагчдын тоо ашиглаж байна гэж үзье. Энэ тохиолдолд үнэлгээгээр хамгийн доод түвшин буюу С аргыг хэрэглэсэн байна гэж үнэлэгдэнэ. Хэрэв ажиллагчдын тооны оронд ажилласан цагийг ашиглавал В аргыг хэрэглэсэн байна гээд В үнэлгээ авна. Харин ажиллагчдын цалин хөлсний мэдээллийг ашиглавал бодит байдалд илүү ойр А аргыг хэрэглэсэн байна гэж үнэлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хэрэв одоогоор ажиллагчдын тооноос өөр мэдээлэл байхгүй, түүнийгээ тооцоонд ашиглаж байвал цаашид мэдээллийн чанар, бодит байдлыг сайжруулахын тулд тухайн аж ахуйн нэгжийн ажиллагчдын цалингийн мэдээллийг бүс нутгаар цуглуулах шаардлагатай болж байна.

2. Бүсийн түвшинд ДНБ тооцох арга зүйд өгөх зөвлөмж

1. ҮСХ-ны даргын 2013 онд батласан “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлогыг тооцох аргачлал”-д “Аймаг, нийслэлийн ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар тооцох арга зүй” гэж тусдаа бүлэг байна. Бүсийн ДНБ-ийг тооцох аргачлал нь тусдаа байсан нь аймаг, нийслэлийн статистикийн хэлтсийн хувьд илүү тохиромжтой байх болов уу. Иймд ДНБ-ийг тооцох ерөнхий аргачлалаас салгаж, “Бүс нутгийн ДНБ-ийг тооцох аргачлал” гэж одоогийн аргачлалын төсөл дээрээ үндэслэн гаргах нь зүйтэй.
2. Бүс нутгийн ДНБ-ийг тооцох аргачлалд ҮСХ-ний холбогдох мэргэжилтэнтэй хамтран найрлагын болон агуулгын засварыг орууллаа. (Хавсралт-1)

3. Өнөөгийн байдлаар ҮСХ нь бүсийн түвшинд ДНБ-ыг тооцохдоо Нэгтгэх арга буюу “Top down” аргыг ашиглан тооцож байна. Өөрөөр хэлбэл улсын түвшинд хийгдсэн тооцоог аймгийн холбогдох үзүүлэлт ашиглан хуваарилан тооцож байна. Энэ нь цаг хугацаа, зардал хэмнэсэн оновчтой аргачлал юм.
4. Харин аймаг, статистикийн хэлтэс дээрхи аргачлалаар тооцсон мэдээлэлд суурилан “Холимог арга”-г хэрэглэх нь илүү зүйтэй болов уу. Өнөөгийн байдлаар аймгийн статистикийн хэлтэсээс сумдаас цахим шуудангаар ирүүлэх нийт 53 албан ёсны статистикийн мэдээ, тайлан авч байна. Дээр нь сумын түвшинд улсын хэмжээний 4-5 судалгаа хийгдэж байна. Энэхүү мэдээлэл дээр суурилан аймгийн статистикийн хэлтэс сумын түвшинд ДНБ-г үйлдвэрлэлийн аргаар тооцох бүрэн боломжтой нь харагдаж байна. Аймгийн статистикийн хэлтэст сумдаас цахим шуудангаар ирүүлэх мэдээ, тайлангийн жагсаалтыг хавсаргав. (Хавсралт-2) Ингэж задалж тооцох нь мэдээллийн чанарыг сайжруулахад нөлөөлөх давуу талтай. Учир нь аймаг ДНБ-ийхээ гүйцэтгэлийг сумдаар задлах тохиолдолд мэдээллийн эх үүсвэртээ хяналт тавих боломжтой болж байна. Жишээ нь, ҮСХ-ноос тооцсон албан бус секторын тооцоо нь аймгийн өөрсдийнх нь тооцоололтой уялдахгүй тохиолдолд шалтгааныг нь тодруулж, аль аль талдаа мэдээллийн чанар сайжирна гэж үзэж байна. Нийт бүс нутгийн ДНБ-ий гүйцэтгэл нь улсын ДНБ-ий гүйцэтгэлтэй тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, аймаг, нийслэлийн ДНБ-ий дүн нь улсынхтай тэнцүү, харин сум, дүүргийн ДНБ-ий гүйцэтгэл аймаг, нийслэлийн ДНБ-ий гүйцэтгэлтэй тэнцүү байна.
5. Бүсийн түвшинд хийгдсэн арга, хийгдсэн тооцооллыг үнэлэх хэд хэдэн аргыг аргачлал тусгаж өгсөн. Эдгээрийг нийцтэй байдлаар нь дараах 3 бүлэгт хуваана. Үүнд:
 - А- арга нь тооцох үзүүлэлтийн бодит утгыг илтгэх эсвэл түүнтэй аль болох ойролцоо утгыг илэрхийлнэ,
 - В-арга нь тооцох үзүүлэлтийн бодит утгаас зөрүүтэй ч хүлээн зөвшөөрөгдөхүйц ойролцоо утгыг илэрхийлнэ,
 1. С-арга нь тооцох үзүүлэлтийн бодит утгаас их зөрүүтэй, тооцооллыг цаашид сайжруулах шаардлагатайг илэрхийлнэ. Тооцооллын арга, үзүүлэлтээ дээрх 3 түвшинд ангилах нь тооцооллын чанарыг хянаж, сайжруулах хэрэгсэл болох бөгөөд цаашид сайжруулалтыг хийх чиглэлээ тогтоох боломжийг олгоно. Эдгээр аргуудыг ашигласнаар мэдээллийн эх үүсвэр хаана дутагдалтай, хүндрэлтэй байна, өнөөгийн хэрэглэж байгаа сайн туршлагаас хэр хол байна гэдгийг ч тодорхойлох боломжтой.
6. Манай орны онцлог байдал, мэдээллийн боломжит байдлаас хамаарч, хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах аж үйлдвэр зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг салбарын хувьд бүс нутгийн түвшний тооцоог шууд хийж, улсын нэгтгэлд авах боломжтой бол зарим салбарын

хувьд улсын түвшинд гарах мэдээллийг ашиглан бүс нутгийн тооцооллыг хийх шаардлага гарч байна.

7. Монгол улсын нийт сумын 90 гаруй хувь нь мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл голлож байгааг илүү анхаарч энэ салбарын бүтээгдэхүүний тооцоог илүү нарийвчилсан байдлаар аргачлалд оруулсан. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг мал тооллогын үр дүнд үндэслэн тооцдог. Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд хүнсэнд бэлтгэсэн мах, сүү болон ноос, арьс ширний үйлдвэрлэл зэрэг орно. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэгч нь суманд байх хэдий ч хэрэглэгч нь сумаас гадуур, бусад суманд, бусад аймагт, нийслэлд ч байна. Хүнсэнд бэлтгэсэн мал буюу хүнсэнд хэрэглэсэн малын тоог дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:
- улсын түвшинд хүнсэнд хэрэглэсэн малын тоо: аймгуудын хүнсэнд бэлтгэсэн малын тооны нийлбэрээр тодорхойлно.
 - Хүнсэнд бэлтгэсэн /хэрэглэсэн/ малын тоо = оны эхний мал + бойжуулсан төл –хорогдол - оны эцсийн мал
 - Сумын түвшинд хүнсэнд бэлтгэсэн малын тоог дээрх балансын зөрүүгээр авах уу эсвэл мал тооллогын үр дүнгээр хүнсэнд бэлтгэсэн гүйцэтгэлээр авах уу, энэ тохиолдолд зөрүүг аймгийн тооцоонд тусгах гэсэн асуудал гарч ирж байна.

Жишээ нь,

Хүнсэнд хэрэглэсэн малын тоо - Баянхонгор		
	Хэрэглээ	Хүнсэнд хэрэглэсэн мал
БҮГД	543 856	177 697
Баянхонгор сум	40 283	9 147
Баацагаан сум	25 929	9 897
Баянбулаг сум	21 274	5 508
Баянговь сум	7 989	7 760
Баянлиг сум	22 915	12 708

Энд сум хооронд болон аймгийн төв, нийслэл рүү худалдсан малын тооны зөрүү нөлөөлж байна. Энэхүү тооцоог тухайн сумын бүтээгдэхүүн, үйлчилгээ гэж тооцож болох юм. Орлогын аргаар тооцохдоо үйл ажиллагааны холимог орлого/ашиг гэж тусгах нь зүйтэй.

8. Албан бус секторын тооцоог Ажиллах хүчний судалгаа (АХС)-ны үр дүнд үндэслэн аймгаар тооцдог. АХС нь өрхөд суурилсан судалгаа. Албан бус секторын

аймгаар гарсан үр дүн нь аймгийн тооцооноос зөрөх тохиолдол, бодит байдалтай нийцэхгүй байдал гарсан. Үүнийг шийдвэрлэхийн тулд хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хүрээ тогтоох судалгааг явуулсан байна. Хүрээ тогтоох судалгаа нь аймаг, сумын /нийслэл, дүүрэг/ түвшинд эдийн засгийн үйл ажилллагааны салбараар хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нийт тоо буюу хүрээг гаргах боломжтой. Үүн дээр үндэслэн албан бус секторын тооцоог хийх нь тооцооллын чанар, бодит байдалд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.